# ШИВЭЭГОВЬ СУМЫН МЭДЭЭ



*2024 оны 07-р сарын 01-нээс 2024 оны 07-р сарын 19-ний хооронд хийгдсэн ажлуудаас*

Тулгар төрийн 2233, Их Монгол Улсын 818, Үндэсний эрх чөлөө, тусгаар тогтнолоо сэргээн мандуулсны 113, Ардын Хувьсгалын 103 жилийн ой, Шивээговь сум үүсэн байгуулагдсаны 35 жилийн ойн баяр наадмыг 2024 оны 07 дугаар сарын 08, 09-ний өдрүүдэд тэмдэглэн өнгөрүүллээ. Нээлтийн үйл ажиллагааг Говьсүмбэр аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын дарга Ш.Билэггүмбэрэл, Шивээговь сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын дарга А. Дэлгэрзаяа, Сумын Засаг дарга Ч.Сугармаа нар нээж, наадамчин олонд баяр наадмын мэндчилгээ дэвшүүллээ. Нээлтийн үеэр Үндэсний их баяр наадмыг угтан улс, орон нутгийнхаа эдийн засаг, нийгмийн хөгжилд үнэтэй хувь нэмэр оруулан төрийн дээд одон медалиар шагнагдаж байгаа иргэддээ хүндэтгэл үзүүлэх мөн салбарын болон аймаг, орон нутгийн шагналаар шагналаа.



Онцгой байдлын Ерөнхий газрын даргын 2024 оны 05 дугаар сарын 29-ний өдрийн А/178 дугаар тушаал, Аймгийн Засаг даргын 2024 оны 06 дугаар сарын 06-ны өдрийн А/187 дугаар “Шуурхай штаб байгуулах тухай” захирамжийг үндэслэн сумын Засаг даргын 2024 оны 06 дугаар сарын 21-ний А/80 дугаар захирамжаар “Сумын шуурхай штаб”-ыг байгуулан, томилгоожуулан ажилласан байна. Үер усны аюулын үед ашиглах шаардлагатай тоног төхөөрөмжийн судалгааг гаргаж, бэлэн байдалд бэлтгэн, нэмэлтээр худалдан авах, онцгой байдлын бэлтгэл хангах үүднээс сумын Онцгой байдлын “Гамшгийн зардал”-аас 5 сая төгрөгийн төсвөөр тоног төхөөрөмж нэмж авахаар ажиллаж байна.






# Байгаль орчны чиглэлээр

“Хог хаягдлын менежмент” арга хэмжээний хүрээнд төсвийн байгууллагууд, ААН-үүд 14 хоног тутам өөрийн эзэмшлийн 50м хүртэлх газрын хог хаягдлыг цэвэрлэж байна. Мөн хог хаягдлын хураамж тогтоохтой холбоотой иргэдээс авах саналыг цахимаар болон цаасаар боловсруулж сумын олон нийтийн сүлжээнд байршуулсан. Эхний байдлаар цахимаар 21, цаасаар 35 санал аваад байна.





# Байгаль орчны чиглэлээр

Сумын хэмжээнд золбин нохой муур устгалын ажлыг 2024 оны 07 дугаар сарын 04-ний өдөр зохион байгуулан ажилласан. Устгалаар 1-15-р байр, зүүн гэр байр, урд гэр байр маршрутаар нохой устгалыг хийж, 27 нохой 18 муурыг устгаж 3 кг ариутгалын бодисоор  халдваргүйжүүлэлт хийж булж устгаад байна.





# Хэвлэл мэдээллийн чиглэлээр

Өнгөрсөн 14 хоногийн байдлаар “Шивээговь сум мэдээ” цахим хуудсанд нийт 54 мэдээ мэдээлэл байршуулснаас 42 мэдээг байгууллагаас бэлтгэн байршуулж, 12 мэдээг бусад байгууллагаас шэйрлэж мэдээллэсэн байна.

Нэг цэгийн үйлчилгээг операторын горимд шилжүүлснээр e-mongolia цахим системээс 2024 оны 07-р сарын 01-нээс 2024 оны 07-р сарын 19-ний байдлаар нийт 94 лавлагааг иргэдэд үзүүлсэн байна. Үүнд:

| № | Үйлчилгээний нэр | Тоо |
|---|---|---|
| 1 | Иргэний үнэмлэхийн лавлагаа | 16 |
| 2 | Үл хөдлөх эд хөрөнгө өмчилж байгаа болон шилжүүлсэн тухай лавлагаа | 10 |
| 3 | Үл хөдлөх хөрөнгийн лавлагаа | 27 |
| 4 | Шинжилгээний хариу авах | 2 |
| 5 | Шүүхийн шийдвэрээр бусдад төлбөргүй эсэх тодорхойлолт | 4 |
| 6 | Малчны тодорхойлолт | 2 |
| 7 | Гэрлэсний бүртгэлийн лавлагаа | 1 |
| 8 | Мал тооллогын лавлагаа | 1 |
| 9 | Иргэний оршин суугаа газрын хаягийн бүртгэлийн лавлагаа | 10 |
| 10 | Зээлийн мэдээллийн лавлагаа | 4 |
| 12 | Нийгмийн даатгал шимтгэл төлөлтийн талаарх тодорхойлолт | 4 |
| 13 | Хуулийн этгээдийн дэлгэрэнгүй лавлагаа | 11 |
| 15 | Төрсний бүртгэлийн лавлагаа | 2 |
| **Нийт - 94** | | |






# Хөдөлмөр, халамж үйлчилгээний чиглэлээр

2024 оны 07-р сарын 05-наас 07-р сарын 18-ны байдлаар хөдөлмөр эрхлэлт болон халамжийн үйлчилгээг нийт 34 иргэнд хүргэж ажиллаж, хөдөлмөр эрхлэлтийг дэмжих чиглэлээр 10 иргэнд, нийгмийн халамжийн 11 төрлийн үйлчилгээг 24 иргэнд хүргэсэн. Үүнд:

1. Хүүхдийн мөнгөн тэтгэмж шинээр-3
2. Цалинтай ээж-3 иргэн
3. Амралт сувиллын эрхийн бичиг -1 иргэн
4. Хиймэл шүдний үнийн хөнгөлөлт – 2 иргэн
5. Ахмадын рашаан сувиллын үнийн хөнгөлөлт – 1 ахмад
6. Хөгжлийн бэрхшээлтэй иргэний рашаан сувиллын үнийн хөнгөлөлт-1 иргэн
7. Ахмад настны асаргаа – сунгалт 1, шинээр 1 иргэн
8. Бүтэн өнчин хүүхдийн асаргаа – сунгалт 1 иргэн
9. Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн асаргааны сунгалт -1 иргэн
10. Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн асрагч солих-1 иргэн тус тус үйлчилгээ үзүүлсэн байна.

# Орон нутгийн хөгжлийн сангийн үйл ажиллагааны чиглэлээр

Нийтийн эзэмшлийн орон сууцны 3-р байрны техникийн давхрын шугам сүлжээний өргөтгөл шинэчлэлийн ажлыг хүлээн авах ажлын хэсгийг сумын Засаг даргын 2024 оны 07 дугаар сарын 02-ны өдрийн А/88 дугаар захирамжаар 9 хүний бүрэлдэхүүнтэйгээр томилж, тус ажлыг 2024 оны 07 дугаар сарын 04-ний өдөр 100%-ийн гүйцэтгэлтэйгээр хүлээж аваад байна.






## Орон нутгийн хөгжлийн сангийн үйл ажиллагааны чиглэлээр

Шивээговь сумын 2024 оны Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хийгдэх Ус хангамжийн нэмэлт их үүсвэр, шугам сүлжээний автоматжуулалтын ажил, Хуучин хог хаягдлыг булшлах, шинээр хогийн цэг байгуулах ажил, Цэцэрлэгийн хашааг шинэчлэх ажил, сумын Нэрт багийн нутаг дэвсгэрт Нийтийн биеийн тамирын талбай/хөл бөмбөгийн талбай/ байгуулах зэрэг ажлууд хийгдэж, 30-70%-ийн гүйцэтгэлтэй явагдаж байна.








# Санхүү албаны цаг үеийн мэдээ

Орон нутгийн татварын орлого 2024 оны 07 дугаар сарын 19-ний байдлаар 16 төрлийн татварын орлого гүйцэтгэлээр 1,200,643,546 төгрөг бүрдэж, биелэлтээр 90.46%-тай бүрдсэн байна.

**ШИВЭЭГОВЬ СУМЫН ОРОН НУТГИЙН ТАТВАРЫН ОРЛОГЫН БИЕЛЭЛТ**

| | Татварын төрлийн нэр | Төрийн сангийн данс | Жилийн батлагдсан төлөвлөгөө | Өссөн дүнгээр | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | | | Төлөвлөгөө | Гүйцэтгэл | хувь |
| 110001 | Цалин, хөдөлмөрийн хөлс, тэдгээртэй адилтгах орлогоос суутгасан татвар | 100220300901 | 1,784,520,500 | 1,071,843,300 | 931,254,613.17 | 86.88 |
| 110002 | Үйл ажиллагааны орлогын албан татвар | 100220300911 | 3,500,000 | 2,030,000 | 5,025,434.03 | 247.56 |
| 110008 | Суутгагчийн ХХ-д олгосон ОАТ / шууд бус орлого/ | 100220300912 | 6,000,000 | 3,000,000 | 119,761,061.99 | 3,992.04 |
| 110003 | Хөрөнгийн орлого | 100220300975 | 28,000,000 | 15,600,000 | 26,249,524.80 | 168.27 |
| 110004 | Хөрөнгө борлуулсны ОАТатвар | 100220300962 | 25,000,000 | 13,500,000 | 6,899,200.00 | 51.11 |
| 110101 | Хувь хүний ОАТ-ын буцаан олголт | 100220300912 | (90,000,000) | (66,500,000) | | - |
| 113004 | Малын тоо толгойн албан татвар | 100220300917 | 45,000,000 | 22,500,000 | 7,406,900.00 | 32.92 |
| 113001 | Үл хөдлөх эд хөрөнгийн албан татвар | 100220300921 | 320,000,000 | 160,000,000 | 50,535,716.14 | 31.58 |
| 113002 | Бууны албан татвар | 100220300922 | 1,070,000 | - | 60,000.00 | #DIV/0! |
| 118001 | Улсын тэмдэгтийн хураамж | 100220300941 | 3,500,000 | 1,750,000 | 550,000.00 | 31.43 |
| 118006 | Түгээмэл тархацтай ашигт малтмалын нөөц ашигласны төлбөр | 100220300948 | 15,000,000 | 7,050,000 | 540,000.00 | 7.66 |
| 118009 | Хог хаягдлын үйлчилгээний хураамж | 100220300947 | 18,000,000 | 10,500,000 | 3,308,500.00 | 31.51 |
| 118101 | Газрын төлбөр | 100220300943 | 172,000,000 | 86,000,000 | 16,670,634.40 | 19.38 |
| 118101 | Газрын үл хөдлөх эд хөрөнгийн АТ | 100220300923 | - | - | 15,481.00 | #DIV/0! |
| 113001 | Иргэний УХЭХАТ | 100220300924 | - | - | 684,000.00 | #DIV/0! |
| 110002 | Иргэний эрх борлуулсны орлого | 100220300916 | - | - | 22,480.00 | #DIV/0! |
| 120003 | Татварын торгуулийн орлого | 100220300952 | - | - | 31,660,000.00 | #DIV/0! |
| | **НИЙТ** | | **2,331,590,500** | **1,327,273,300** | **1,200,643,546** | **90.46** |



# АНХААРАЛ ХАНДУУЛСАНД БАЯРЛАЛАА